Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Цахим боловсролын бодлого, төлөвлөлт хэрэглэгдэхүүн, цахим сургалт, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч, Гомбосүрэн Батнэмэх

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Хот, хөдөөгийн болон нийгэм, эдийн засгийн хувьд ялгаатай бүлгийн хүүхэд, залуучуудын боловсролын чанарын ялгааг арилгаж, малчин эцэг, эх, асран хамгаалагчийн дэргэд бага боловсрол эзэмших боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 1 | Хот, хөдөөгийн болон нийгэм, эдийн засгийн хувьд ялгаатай бүлгийн хүүхэд, залуучуудад зориулсан орон зай, цаг хугацаанаас үл хамаарах цахим боловсролын арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Боловсролын үйлчилгээг цахимаар авсан хөдөө, орон нутгийн болон нийгэм, эдийн засгийн хувьд ялгаатай бүлгийн хүүхэд, залуучуудын тоо | 15265 | 15265 | Боловсролын сайдын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” А/216 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Ерөнхий боловсролын зарим сургуулийн удирдлагын систем (SMS), суралцахуйн удирдлагын систем (LMS)-ийн суурилуулалт, нэвтрүүлэлт, ашиглалт, хэрэгжилт, үр дүнд хяналт шалгалт хийх ажлын хэсэгт ажилласан. Удирдамжийн хүрээнд ажиллаж, хяналт шалгалтын дүгнэлтийг систем хэрэгжүүлсэн байгууллагын төлөөлөлтэй уулзаж танилцууллаа. Амжилт дотком ХХК-тай гэрээ байгуулсан ерөнхий боловсролын сургуулийн гэрээний талаар холбогдох мэдээллийг ирүүлж хамтран ажиллах 2025 оны 2/614 тоот албан бичгийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Мөн Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд солилцож | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгаа мэдээллийг нэгтгэн дүгнэлт гаргаж ирүүлэх 2025 оны 7/591 тоот албан бичгийг БМТТ-д хүргүүллээ. Дээрх 2 байгууллагаас мэдээллийг авч тулган Амжилт дотком ХХК-тай гэрээ байгуулсан ерөнхий боловсролын сургуулийн мэдээллийг нэгтгэн гаргаж зөрчилтэй эсэхийг тодруулан ажилласан. Хяналт шалгалт хийсэн дүгнэлтийг Том-Амжилт ХХК,-д 2025 оны 2/1227 тоот, “ECM” ХХК-д 2025 оны 2/716 тоот албан бичгээр хүргүүлсэн. “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” (EQUAL) төслийн хүрээнд “Хосолсон сургалтыг туршин нэвтрүүлэхэд сурагч, эцэг эх, асран хамгаалагчид, багш нарын оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилготой цахим контентын уралдааны удирдамж”-ийг хянаж, Төрийн нарийн бичгийн дарга батлуулсан. Уг уралдааныг зохион байгуулж, уралдааны үр дүнг тайлагнах албан бичгийн БЕГ-т 2/2214 тоот албан бичгээр хүргүүлсэн. БЕГ-ын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/77 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг уралдаанд ирүүлсэн 23 бүтээлтэй танилцан шалгаруулж, шагнал гардуулсан. “ISO/IEC 2382-36 Information technology-Vocabulary - Part 36: Learning, education and training” цуврал стандартын төслийг хэлэлцүүлэхээр Стандарт, хэмжил зүйн газарт албан бичгээр хүргүүлж техникийн хорооны хуралдаанаар дэмжигдлээ.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.2. Цахим сургалтын байгууллагыг байгуулж, суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадварыг албан боловсролын сургалтад дүйцүүлэн дэвшин суралцаж, төгсөх боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 2 | Цахим сургалтын | "Мэдлэ" цахим сургалтад | 15265 | 15265 | Цахим сургалтын байгууллага байгуулах талаар судлан 4 хувилбар гаргаж | 1-р сар, 2-р сар, | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагыг байгуулж, суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадварыг албан боловсролын сургалтад дүйцүүлэн дэвшин суралцаж, төгсөх боломжийг бүрдүүлнэ. | хамрагдсан суралцагчийн тоо | | | танилцуулсан. Өгсөн чиглэлийн дагуу Боловсролын яамны харьяа “Цахим сургалтын байгууллага байгуулах” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, санал авах бичгийн төслийг боловсруулж холбогдох газар, хэлтсийн дарга нарт танилцуулсан. “Цахим сургалтын байгууллага” байгуулснаар шаардагдах санхүүжилтийн тооцоо, судалгаа иргүүлэх талаар 7/446 тоот албан бичгийг БМТТ-д хүргүүллээ. Боловсролын ерөнхий хуулийн 26.1.11-д заасан "зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам батлах" заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн хүрээнд хийгдэж байгаа ажилтай танилцан зайн болон цахим сургалтад тавигдах нийтлэг шаардлага болон үнэлгээний талаар БНБТГ-ын дарга, төслийн гүйцэтгэгч нартай хамтран уулзалт хийлээ. Төслийн хүрээнд хийгдэж байгаа “Хосолсон сургалтад тавигдах нийтлэг шаардлага” болон “Багшийн хосолсон сургалтын ур чадварт тавигдах нийтлэг шаардлага”-ын төслийн уулзалт хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Боловсролын яамны БНБТГ, ЦБГ, Боловсролын ерөнхий газар, Монгол Улсын Боловсролын их сургууль, ерөнхий боловсролын сургуулийн төлөөлөл оролцсон. Зайн болон цахим сургалт зохион байгуулах, үнэлэх, дүйцүүлэх журмын эхний төслийг боловсруулан БНБТГ-ын даргад хүргүүлсэн. ЕБГ-ын даргад танилцуулга хийсэн. Журмын төслийг холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хэрэгжиж байгаа холбогдох дүрэм, журам, зөвлөмж, удирдамж болон олон улсын туршлага, | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | стандарт, шаардлагыг судлан боловсруулсан. Мөн Боловсролын ерөнхий газрын Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын дарга, мэргэжилтнүүдтэй хэлэлцүүлээд байна. “Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль”-ийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэлэлцүүлгийг зохион байгуулах дэд ажлын хэсгийг Боловсролын сайдын 2025 оны А/105 дугаар тушаалаар байгууллаа. Хавсралт: 5 файл | | |
| 1.5. Боловсрол сургалтын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи нэвтрүүлж, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан контент, сургалтын сан, платформ, мэдээллийн технологийн хөтөлбөр, агуулгыг боловсруулж, хиймэл оюунд суурилсан цахим сурах бичгийг хөгжүүлж, хүүхэд бүрд цахим төхөөрөмж олгоно. | | | | | | | |
| 3 | Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжихөд дэмжих, ачааллыг бууруулах зорилгоор хиймэл оюунд суурилсан багшийг виртуал туслахтай болж, Багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний платформыг хөгжүүлж, нэвтрүүлнэ. | Виртуал туслах багш хөгжүүлсэн судлагдахууны тоо | 1 | 1 | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд дараах ажлыг хийж байна. 1.”Багшийн цахим сургалтын “bgsh.edu.mn” платформыг сайжруулах” ажлын зөвлөх сонгон шалгаруулах зорилго бүхий ТНБД-ын 2024 оны “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/106 дугаартай тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан ажилласан. 10 бүлэг бүхий ажлын даалгавар боловсруулан ТНБД-аар батлуулсан. Боловсролын яам Старсофт ХХК-тай Loan No:L3594-Mon, Contract No. CS-05/СХОГ-2025/147 гэрээг 2025 оны 5 сарын 8-ны өдөр байгуулсан. 2.“Багшийн цахим сургалтын “bgsh.edu.mn” платформыг бусад платформтой нэгтгэх, багшийн хөгжлийн платформыг хөгжүүлэх” ажлын зөвлөх сонгон шалгаруулах зорилго бүхий ТНБД-ын 2025 оны “Үнэлгээний хороо | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулах тухай” А/46 дугаартай тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан ажилласан. Систем интеграци хийх зөвлөх компанийн ажлын даалгаврыг боловсруулан ажлын даалгаврыг АХБ-д хянуулж, худалдан авах ажиллагаа эхлүүлэх зөвшөөрөл авахаар болсон. 3.”Багшийн цахим bagsh.edu.mn, газарзүйн мэдээллийн системд суурилсан хөрөнгө оруулалтын нэгдсэн систем болон салбарын бусад системийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх” ажлын зөвлөх сонгон шалгаруулах зорилго бүхий ТНБД-ын 2025 оны “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/48 дугаартай тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан ажилласан. 18 барааны нэр бүхий ажлын даалгавар боловсруулан ТНБД-аар батлуулсан. Монголын анхны 3D виртуал дижитал шилжилтийн нэгэн жишээ болж байгаа ба боловсролын салбарт технологийг үр дүнтэй ашиглах шинэ боломжийг нээн өгч компьютероор байгуулсан виртуал орчинд хэрэглэгч өөрийн аватар дүрийн тусламжтай нэвтэрч, бодит амьдрал дээр ч турших боломжгүй тэрхүү туршлагаас хамтдаа суралцах, харилцах боломжийг олгосон. Нийслэлийн ЕБС-ийн 2, 5, 84-рсургуулийн сурагчид виртуал сургуулийн анхны хэрэглэгчид болсон. Багш нарын цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор танхим болон цахим хэлбэр хосолсон сургалтад 891 багшийг хамруулсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 4 | Дээд боловсролын судалгааны ажлын | Цахим системийн хөгжүүлэлтийн хувь | 10 | 20 | Судалгааны ажлын хуулбарлалтын шалгах журмыг Дээд боловсролын газартай хамтран шинэчлэн боловсруулж Боловсролын сайдын 2025 оны “Журам шинэчлэн батлах | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулбарлалтыг шалгах нэгдсэн системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ. | | | | тухай" А/55 дугаар тушаалаар батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдад 1/646 тоот албан бичгээр Боловсролын сайдын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/55 дугаар тушаалаар батлагдсан "Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журам" -ыг Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/1711 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Боловсролын сайдын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/55 дугаар тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7188 дугаарт бүртгэсэн. Боловсролын сайдын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/55 дугаар тушаалаар батлагдсан судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журмыг хэрэгжүүлэхээр Шинжлэх ухаан технологийн сангийн Мэдээллийн сан, маркетингийн хэлтсийн дарга, Esan байгууллага, төрийн өмчийн зарим их сургуулийн дундын удирдах зөвлөлийн Ажлын албаны дарга, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Ахисан түвшний хөтөлбөрийн албаны дарга, Номын сангийн эрхлэгч нартай уулзалт хийж мэдээлэл солилцож цаашид хийх ажлын талаар ярилцлаа.<br>Хавсралт: 1 файл | 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 5 | Шинэчилсэн хөтөлбөртэй нийцүүлэн багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан контент, | Сургуулийн өмнөх боловсролын цахим контентын систем хөгжүүлэлтийн хувь, Мэдлэ контентын санд | 0 / 130,000 / 0 / 304,900 / 5 | 10 / 140,000 / 0 / 304,500 / 3 | Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/18 дугаар тушаалаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийн цахим систем нэвтрүүлэх /6-12анги/ ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Үүнд: Төрийн өмчийн ерөнхий | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтын сан, платформ, мэдээллийн технологийн хөтөлбөр, агуулгыг боловсруулж, нэвтрүүлнэ. | хандсан хэрэглэгчийн тоо, Бага ангийн математикийн Эдүтэн платформыг ашиглаж буй суралцагчийн тоо /2025 онд II-V анги, 2026-2028 онд I-V анги/, Мэдээллийн технологийн мэргэжлийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим сургалт хэрэгжүүлж буй политехник коллежийн тоо | | | боловсролын сургуулийн 6-12-р ангид хичээл заадаг 22,680 багш, 377,804 суралцагчийн medle.mn домайн өргөтгөлтэй и-мэйл хаяг баталгаажуулалтыг хийсэн бөгөөд medle.mn хаягийн бүртгэлийн зөрчилтэй 800 гаруй багш нарт шинээр хаяг нээсэн. ЕБС-ийн 6-12-р ангийн 100 сурах бичиг системд байршсан. Унгар улсын Сегед хотод 11 мэргэжилтэн ажиллаж, 200 гаруй 3D үзүүлэн, дижитал хичээлийн Монгол хэл рүү орчуулагдан орсон агуулгын үг хэллэгийн буруу сонголт, утга найруулга, дүрмийн алдаа зэрэгт сайжруулалт хийн 8 төрлийн дижитал хичээл боловсруулан, 3 төрлийн 3D үзүүлэн бэлтгэн, Монгол хэл рүү орчуулагдсан хэрэглэгчийн гарын авлагын утга найруулгыг засан сайжруулсан. Цахим сургалтын платформ нэвтрүүлэхэд шаардлагатай серверийн техникийн үзүүлэлтийг хангах сервер байхгүй учир Унгар улсаас 2 сервер авчран суурилуулах болсон бөгөөд одоогийн байдлаар нэг серверийг Боловсролын ерөнхий газарт суурилан домайн хаягуудыг Монгол улсын серверт шилжүүлэн суулгасан. Сургагч багш бэлтгэх сургалтын удирдамжийг боловсруулж, 30 багшид сургалтыг зохион байгуулж, Mozaweb болон Mozabook-д хэрхэн нэвтрэн орох, платформын бүтэц, хэрхэн ажиллах талаар мэдээлэл өгсөн. Багш, сурагчдад зориулсан цахим сургалтын гарын авлагын анхан түвшин болон ахисан түвшин монгол хэл рүү орчуулагдан бэлэн болсон. Мөн 16 сургалтын видео бичлэгийг бэлтгэн https://www.youtube.com/@MozaikEducation сувагт байршуулсан. Сургагч, багш нараар дамжуулан орон нутаг, нийслэлд түгээн дэлгэрүүлэх ажил хийж байна. • Багш, | 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сурагчдад зориулсан цахим сургалтын гарын авлага, анхан түвшин, ахисан түвшин Монгол хэл рүү орчуулан бэлэн болсон. 16 сургалтын видео бичлэгийг бэлтгэн https://www.youtube.com/@MozaikEducation сувагт байршуулсан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.9. Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хантан ажиллана. | | | | | | | |
| 6 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг хантан ажиллана. | Мэдээллийн тоо | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | Ерөнхий боловсролын сургуулиудад удирдахуйн болон сургалтын систем хэрэгжүүлж байгаа Амжилт дотком ХХК-ны талаар Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1-р хэлтэст Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Шинэ алхам сургууль болон Дархан-Уул аймгийн боловсролын газраас дамжин ирсэн хуурамч албан бичгийг шалгуулах 2025 оны 12/1562 тоот албан бичгийг хүргүүлсэн. ЮНЕСКО нь G77+Хятадын дэмжлэгтэйгээр Багш, суралцагчдын цахим ур чадварын асуудлаарх Ази, Номхон далайн бүс нутгийн гишүүн орнуудын 2025 оны 4 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд “Багшийн хиймэл оюун ухааныг ашиглах чадамж”, “Суралцагчдын хиймэл оюун ухааныг ашиглах чадамж” цахим уулзалтад оролцож мэдээлэл авсан. “Багшийн хиймэл оюун ухааныг ашиглах чадамж”-ийн зөвлөмжийг орчуулж байна. "Хиймэл оюуны ёс зүйн тухай" зөвлөмжийг орчуулж бэлэн болгосон. Азийн хөгжлийн банкны боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа төслүүдийн тайлан танилцуулга 2025 оны 2 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдахад оролцож мэдээлэл хамтран ажилласан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Мэдээллийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аюулгүй байдал, технологийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй “СӨРГӨ-1.0” төслийн хүрээнд хийгдэж буй мэдээллийн санд боловсролын салбарын холбогдох мэдээллийг нийлүүлэх талаар хийсэн уулзалтад оролцсон. Монгол дахь Google for Education-ийн хөтөлбөрүүд, Google for Education мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн танилцуулга, Google Educator Groups танилцуулга, Google Vids танилцуулга уулзалтад оролцлоо.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.10. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | | | | | | | |
| 7 | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах | Биелэлтийн хувь | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | 100 | Боловсролын сайдын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” А/37 дугаар тушаалаар батлагдсан хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журамд санал өгч ажилласан. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нэмэлт санхүүжилтийн хүрээнд БНЭУ-ын “Мега Инженеринг Энд Инфрастракчурс Лимитед” компанитай төслийн Лицензтэй технологийн байгууламж (EPC 04)-ийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаж, Тусгайлан өгөх саналгүй, зарчмын хувьд дэмжиж байгаа 2025 оны 1/628 тоот албан бичгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүллээ. “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаж, тусгайлан өгөх саналгүй, зарчмын хувьд дэмжиж байгаа талаар албан бичгээр хариу хүргүүлсэн. Мэдээлэл, технологийн үндэсний паркаас 2025 оны 1/128 тоот албан бичгээр мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн чиглэл бүрд шаардагдах чадварын түвшнийг тодорхойлох, ур чадварыг үнэлэх бодит шалгуур тогтоох зорилгоор мэдээллийн технологийн инженерийн шалгалтыг шат дараатайгаар нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа болон мэдээллийн технологийн хичээлийн хөтөлбөрт зарим өөрчлөлт оруулах талаар ирүүлсэн хүсэлтийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд албан бичгээр уламжлан хүргүүлсэн.<br>Хавсралт: 3 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлж байна. | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | Төрийн албаны тусгай шалгалт өгсөн. Дараах хуулийг судалж ажлын хэрэгцээнд ашиглаж байна. Үүнд: Байгууллагын нууцын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хууль,Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль,Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомж, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын гэрээ, НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын гэрээ, Шилэн дансны тухай хуулийг уншиж судаллаа. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна. | Сургалтад хамрагдсан байна. | - | MS POER BI сургалтад хамрагдан гэрчилгээ авна. | POWER BI сургалтад 2024 оны 1 сарын 15-16-ны өдрүүдэд суралцаж төгссөн. Сертификат №202501633. Дараах сургалтад хамрагдсан. Үүнд: • Их өгөгдөлд суурилсан боловсролын бодлого, төлөвлөлт, • Төрийн чадамжийг бүрдүүлэх нь, Төрийн албан дахь ёс зүйн боловсрол • Боловсролын хувирган өөрчлөлт • Хиймэл оюун, технологийн хувьсгал • Хувь хүн, байгууллагын кибер аюулгүй байдал • Кибер гэмт хэргийн хуулийн хариуцлага • Хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээлийн тухай • Орон нутгийн хамгаалалтын тухай хууль болон Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийн талаар | 6-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Цахим боловсролын бодлого, төлөвлөлт хэрэглэгдэхүүн, цахим сургалт, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч, Гомбосүрэн Батнэмэх /................................................/ Огноо: .........................